## Тойм байгуулалт М1:400




## Тайлбар

Ерөнхий хэсэг:

Дархан-Уул аймаг, Орхон сум, Соёлын төвийн барилгын засварын халаалт, агаар сэлгэлтийн ажлын зургийг барилга, архитектурын зургийн даалгавар, газар дээр нь хийсэн хэмжилт, судалгааг үндэслэн зураг төслийн "ЗӨВ ЧИГЛЭЛ" ХХК-д боловсруулав.

Дараах норм дүрмүүдийг мөрдлөг болгон хийлээ:

1. Барилгад хэрэглэгдэх уур амьсгал, геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09
2. Барилгын дулаан хамгаалалт БНбД 23-02-09
3. Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНбД 41-01-11
4. Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03

1. Халаалт, Агаар сэлгэлтийн системийн тооцоог дараах нөхцөлөөр тооцлоо..
   - Гадна агаарын хэм хүйтний улиралд -35.3 °C
   - Гадна агаарын хэм хүйтний улиралд +20.0 °C
2. Дулаан зөөгчийн температур
   - 2.1 Халаалтын системийн өгөх усны хэм 90°C
   - буцах усны хэм 70°C
3. Зонхилох өрөөний хэм
   - 3.1 Анги, танхим 20-22°C

Халаалтын дулаан хангамжийн эх үүсвэр нь байрын дулаан хангамж байна.
Халаалтын систем нь доороос түгээлттэй, 2 хоолойт мухардмал систем ба халаалтын өгөх, буцах шугам 1-р давхрын шалан дээгүүр угсрагдахаар төлөвлөв. Халаалтын системийн буцах шугам нь шалан дээгүүр хэвтээ явах шугамыг зориулалтын хавтангаар хааж далдална. Халаалтын системийг барилгын узелийн хуваарлагчаас холбогдохоор төлөвлөв. Урлагын заал болон спорт зааланд халаалтын өгөх шугам нь 1-р давхрын таазан доогуур, буцах шугам нь шалан дээгүүр явахаар төлөвлөж өгсөн. Мөн урлагын заалны гадна хананд байгаа халаах хэрэгсэлийг үлдээж, шинээр төлөвлөх шугам хоолойд холбож өгнө.
Магистрал шугамын салбарлаж байгаа зангилаа руу i=0.002 мм-ийн налуутай угсрах. Жигүүрийн хаалт, подводка бүрт хоёр тохируулах вентиль, босоо шугамд хаалт, ус бүүлгэгч заавал хийж өгнө.
Халаах хэрэгсэлийн хүчин чадлыг Ватт-аар, мөн маркаар тойм болон байгуулалтын зурагт бичиж өгөв.
Халаалтын системийг 100% одоо байгаа материалын тоо хэмжээгээр бүрэн бүүлгаж шинээр хийхээр төлөвлөв. Одоо байгаа халаах хэрэгсэлийн 30% -ийг сайтар угааж, даралтаар битүүжлэлийг шалгаж эргүүлэн ашиглах, тооцоогоор нэмсэн ба одоо байгаа халаах хэрэгсэлийн тоо хэмжээ нь 405 ширхэг халаах хэрэгсэл байгаа бөгөөд тэдгээрээс 125 ширхэг ширмэн радиоторын дахин ашиглах, нийт шинээр М140 А маркын 280 ширхэг орос стандартын шаардлага хангасан ширмэн радиоторыг шинээр нэмж авч угсархаар төлөвлөв.

Агаар сэлгэлтийн механик системүүдийг төлөвлөсөн. Спорт зааланд агаар сорох С-1 систем мөн О-1 системийг төлөвлөв. Одоо байгаа гадна хананд гаргасан нүхийг ашиглан агаар сорох болон оруулах системийг төлөвлөж өгсөн болно. Агаар сорох ба оруулах системийг шалнаас 4,20 түвшинд төлөвлөж өгсөн болно.

Цахилгааны өрөөний дамжуулах ган хоолой болон холбох хэрэгсэлийг гагнаж холбоно. Халаалтын дулаалгатай яндан хоолойг материалын түүвэрт заасан техникийн үзүүлэлтийн материалаар дулаална. Дулаалгагүй ган яндан хоолойг тосон будгаар хоёр дахин будна. Яндан хоолойг будахын өмнө зохих даралтаар шахаж гидравлик туршилт хийх хэрэгтэй. Халаалтын системийг угсарч дууссаны дараа заслын ажил эхлэхийн өмнө 6 атм даралттай усаар шахаж шалгана. Яндан хоолойн гагнуурын ажлыг БНбД 40-06-15 -ыг мөрдлөг болгох ба ажлын даралтаас 1.5 дахин их, гэхдээ 0.6 мПа багагүй шахаж шалгана. Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ техник аюулгүй ажиллагааны норм дүрмийг баримтлан ажиллах хэрэгтэй.

## Зургийн жагсаалт

| Д/д | Фор-мат | Нэрс | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | А3 | Тайлбар бичиг, Тойм байгуулалт, Зургийн жагсаалт | ХАС-1 |
| 2 | А3 | Халаалт, агаар сэлгэлтийн үндсэн үзүүлэлт, Таних тэмдэг | ХАС-2 |
| 3 | А3 | Халаалт агаар сэлгэлтийн системийн тэмдэглэгээ, техникийн үзүүлэлт | ХАС-3 |
| 4 | А3 | Халаалтын системийн материалын түүвэр | ХАС-4 |
| 5 | А3 | Агаар сэлгэлтийн системийн материалын түүвэр | ХАС-5 |
| 6 | А3 | 1-р давхрын халаалтын системийн байгуулалт | ХАС-6 |
| 7 | А3 | 1-р давхрын агаар сэлгэлтийн системийн байгуулалт, тойм | ХАС-7 |
| 8 | А3 | Халаалтын системийн тойм | ХАС-8 |

ТАЙЛБАР:

| Д/д | Огноо | Засвар өөрчлөлт |
|---|---|---|

Үе шат: АЖЛЫН ЗУРАГ

ЗӨВ ЧИГЛЭЛ — барилгын зураг төсөл — ЗӨВ ЧИГЛЭЛ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, Цэргийн хотхон, 4-484 тоот

| | |
|---|---|
| Инженер | О.Батцоож |
| Гүйцэтгэсэн | О.Батцоож |
| Шалгасан | |

Дархан-Уул аймаг, Орхон сум, Соёлын төвийн барилгын халаалтын засвар

**Тайлбар бичиг, тойм байгуулалт, зургийн жагсаалт**

| Масштаб: | Зургийн дугаар: | Хуудас: |
|---|---|---|
| 1: | ХАС-1 | 8 |
| ЕГ Шифр: | ТГ Шифр: 28.10/2019 | Огноо: 2019 |

А3